

## XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮД, ТЭДНИЙГ УЛС ТӨР, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛЫН АМЬДРАЛД ТАТАН ОРОЛЦУУЛСАН НЬ

### Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

Монгол Улсын Их Сургууль Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-  
Археологийн тэнхим, [tgl@num.edu.mn](mailto:tgl@num.edu.mn)


*Түлхүүр үгс:* Эмэгтэйчүүд, жендэр, боловсрол, хөдөлмөр эрхлэлт

**Өгүүллийн товч агуулга:** XX зууны эхэн үеийн эмэгтэйчүүд ноёд баядын хатан, охид, дунд, ядуу, харц ард бүсгүйчүүд хэмээн давхраажиж харилцан адилгүй эрх мэдэлтэй байсан бөгөөд эмэгтэйчүүдийн нийгмийн статус нь ураг төрлийн бүлгийн болон эр нөхрийн нийгэмд эзлэх байр сууриас голчлон шалтгаалж байв. МAA-н үйлдвэрлэлд эмэгтэйчүүд, хүүхдийн оролцоо илүү байдаг болон эрэгтэйчүүдийн нэлээд хэсэг нь нийгмийн үйлдвэрлэлээс хол хөндий сүм, хийдэд шавилан суусан нь дундаж болон дунджаас доогуур амьдралтай эмэгтэйчүүдийг хөлсгүй хөдөлмөрт нухлагдан, боловсорч улс орны хэрэгт оролцох байтугай “хөмөрсөн тогоо”-н дотроо өчүүхэн ч чөлөө завгүй байхад хүргэжээ. Хэдийгээр ухаалаг, гэрийн сайн боловсролтой эмэгтэйчүүд олон арваараа байсан ч “Янтгар хатан зарга шүүдэггүй” хэмээн үзэх хандлага монголчуудын дунд нийтлэг байснаас эмэгтэйчүүдийг төр улсын хэрэгт оролцох оролцоог төдийлөн дэмждэггүй байсан.

1924 онд үндсэн хуулиндаа жендэрийн тэгш байдлыг анх хуульчилж, эмэгтэйчүүдийн улс төр, хөдөлмөрийн болон хувийн эрх чөлөөг элдэв гэмт халдлагаас хамгаалах хэм хэмжээнүүдийг тогтоож өгсөн нь нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцох оролцоог дэмжсэн чухал алхам болжээ. 1930-аад оны үед монгол улс шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг 30 хувьд хүргэж жендэрийн тэгш байдлыг хангахад ихээхэн амжилт олсон бөгөөд, уламжлалт ойлголтыг эвдсэн томоохон өөрчлөлт болсон. Төрийн ивээл дор олон арван сургууль байгуулж үнэ төлбөргүй сургах, гадаадад сурагчдыг илгээх болсон нь нийгмийн оюун санааны амьдралд томоохон өөрчлөлт авчирч, эмэгтэйчүүдийн боловсролын түвшинг дээшлүүлээд зогсохгүй тэднийг гар урлал, хоршооллын үйл ажиллагаанд оролцуулах замаар хөдөлмөр эрхлэлтэнд татан оролцуулсан нь МAA-н хөдөлмөрт нухлагдаж ирсэн дийлэнх эмэгтэйчүүд, тухайн үеийн нийгмийн зохисгүй уур амьсгалын золиос болсон биеэ үнэлэгчдэд нийгмийн амьдралд оролцох, хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх боломж олгож, цаашилаад мэргэжилтэй боловсон хүчин, хөдөлмөрийн сэхээтнүүдийн дунд зохих байр сууриа эзлэх боломжийг олгосон.

XX зууны эхэн үеийн Халхын 4 аймгийн нийт хүн амын 48.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байжээ.

XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮД



**Зураг 1.** Халхын 4 аймгийн хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (1918 он)  
(Майский 2001: 23-35)

Ихэнх хошууны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо харьцангуй зөрүүтэй байсан. Нийтдээ 59 хошуунд эрэгтэйчүүд, 32 хошуунд эмэгтэйчүүд, 13 тамгатай хутагтын харьяат хэсгүүдийн 8-д нь эрэгтэйчүүд, 5-д нь эмэгтэйчүүд тус тус давамгайлж байв (Майский 2001: 34).

Монгол эмэгтэйчүүдийн “...нүүр царай нь аятайхан, үнэхээр ховорхон царайлаг...” бөгөөд үндсэндээ эрэгтэйчүүдтэй адил голдуу улаан, цэнхэр, шар, хөх ягаан гэх зэрэг хурц өнгөтэй урт дээл өмсөнө (Майский 2001: 42). Нөхөрт гарсан эмэгтэйчүүдийн хувцсанд зарим өөрчлөлт гардаг бөгөөд эхнэрүүд толгойгоо онцгойлон гоёдог. Онцгой ёслолын үед малгайны зүүн, баруун талд алт мөнгө, үнэт чулуугаар чимэглэсэн унжлага хэрэглэнэ. Ядуу эхнэрийн зүүлт мөнгөн болон шүрэн чимэглэлээр л хязгаарлагддаг бол зарим баян хүний эхнэр толгой дээрээ олон арван шүр, эрдэнийн чулуу шигтгэсэн 2-3 фунт мөнгөн чимэглэл хэрэглэхийн зэрэгцээ хацартаа ягаан оо энгэсэг тавих бөгөөд энэ нь онцгой эрх ямбыг илэрхийлдэг байв. Мөн тамхины хавтага, гаанс хэрэглэдэг эмэгтэйчүүд цөөнгүй байсан талаар И.Майский дурьдсан байна (2001).

“Тоть шувууны сургааль”-д өгүүлсэнчлэн өсвөр насны охидыг “Сайхан гоо зүстэй бөгөөд санаа сэтгэл номхон дөлгөөн, саруул ухаантай, эхийн сургаалиар явагч, эгч дүү лүгээ эетэй, эсгэх оёход уран, алиа наадгайд дургүй, ахуй биеэ хичээн хадгалаад, ахас ихсийг зэргээр хүндлэгч, уур хилэнгүй” байхыг эрхэмлэх, “Авир дүр нь чөтгөр мэт, асар их ууртай, ааш муутай, ачит эцэг эхээ сургаваас уурлан, ах дүү лүгээ хэрэлдэн хараагч, алиа наргианд маш баясан айл хэсэгч, үйл хийхэд дургүй, үг хов хэлэхэд дуртай, үргэлжид гэрт гадаа гиншин дуулагч, үл бүтэх муу, айх ичихийг үл мэдэн, ажиггүй шалиг үг хэлэлцэн, алиа самуун явдалтай авшгүй муу охин” байхыг цээрлүүлэн сургаж ирсэн нь өгүүлэн буй үеийн охидын зан төлөв, биеэ авч явах байдалд тодорхой хэмжээгээр туссан нь дамжиггүй юм. Хүүхдүүд охид, хөвгүүд ялгаагүй 3-4 наснаасаа хурга тугал хариулж, 6-7 настайгаасаа морь, тэмээ унаж суран

## Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

бод мал хариулж эхлэх бөгөөд энэ үеэс охидууд хувцас оёж шидэх, цай хоол хийх, цагаан идээ бэлдэх ажилд суралцдаг байна. Тухайн үеийн өсвөр насны охидын талаар өгүүлсэн баримт тун ховор байдаг. И.М.Майский нэгэнтээ "...16-тай ягаахан хацартай, инээмсэглэн дүрэлзсэн хар нүдтэй, өтгөн толь хар үсэндээ ягаан лент уясан хөөрхөн амьтан бусдаасаа ялгаран тусна. Тэр охин ёстой л талын цэцэг мэт харагдах агаад түүнээс хаврын цэвэр салхи, эх газрын шорооны ариун үнэр сэнгэнэнэ" хэмээн дуу алдсан байдаг.

Түүнчлэн эхчүүд, эмэгтэйчүүдийн сайн зан чанарын тухайд: "Сайхан гоо зүстэй, санаа сэтгэл нь цэцэн дөлгөөн сайхан, эсгэх оёход уран, самбаа сайт эхнэр, ачит эцэг эхээ хүндлэн, ах дүүтэйгээ зохицон найралдаж, алив хэрэг үйлээ амар бүтээгч, ааль сайтай эхнэр, гэр дэхээ цэвэрлэн засаад, гийчин зочин ирвэл хичээн зочлогч, гэнэдэж буруу үг үл чалчигч, хэрсүү ухаантай эхнэр, хэт хойдын үйлээ бодогч, гэмт явдлаас хичээн зайлагч хянуур ихсийн үгийг сонсогч, гийсэн ухаантай эхнэр, алив хүн бүрд тааламжтай, амны хүнс үл тасрагч, ач үр лүгээ төгссөн, ашид хишигтэй эхнэр, үүр цайхын урд эрт босоод үс зүсээ угаан засагч, үйлээ оёж үтэр бүтээн үдэш орой унтагч, алив барьсан идээ нь арвин, асар хайрлаж үл харамлан, ах дүүсдээ өнгө тал хийгч, авир сайтай эхнэр, учирсан нөхрөө баясган хүндлэгч, урваж хоёр үл аашлагч, улсын зуур худал хов үг хэлэхгүй, ухаан сайн эхнэр" хэмээн эмэгтэй хүний 9 сайн чанарыг дурьдан үлгэрлүүж ирсэн агаад ааш зан сайтай, оёдол үйлэнд уран, ахас ихэст хүндлэлтэй, ариун журамтай эмэгтэйчүүд олны хайр хүндлэл хүлээж байжээ. 1911 оны үндэсний хувьсгалын үр дүнд тогтсон Монгол улсын эзэн хаан VIII Богд Жибзундамба 1914 оны V сарын 14-ний өдөр Дотоод яамны уламжлан өргөсний дагуу зарлиг буулгаж, дэс түшмэл Хайсангийн авааль гэргий Урианхай овогт Түмэнбаярт: "... сурвалжит гэрт төрөөд анх хадамласнаас нааш эевэргүүгээр үйлчлэн дотнолж, гэргийн ёсыг болгоомжлон цэвэр ичимгийгээр хэлхээ журмыг сахиж явсны тулд чамд өргөмжлөл олгуулав. Цэвэр хишгийг сүслэн болгоомжилж явагтаун" (МУИА, А-3, Д-1, хн-97 42 дугаар бичиг. Х 146-148) гэжээ. Мөн Магсар хурцын гэргий У.Гүндсамбуу ажилч хичээнгүйлэн болгоомжилж, цэвэр ичимгийгээр хэлхээ журмыг сахиж явсны тулд (33.ф. А3, д.1, хн 231. х.54) 1919 онд Богд эзний эрдэнийн хас тамга дарж өршөөсөн шар цаасан өргөмжлөл хүртэж байжээ. Ийнхүү монгол бүсгүйчүүдийн цэвэр ичимгийг ааль, ханьдаа халамжтай, үрдээ энэрэлтэй, үнэнч ариун байдлыг нь үлгэр дууриал болгон алдаршуулж тухайн үеийн төр нь үнэлж ирсэн байна. Гэсэн хэдий ч энэхүү төрийн хайр хишгийг хүртэх хувьгүй төрсөн олон мянган эмэгтэйчүүд гэрийн хөлсгүй хөдөлмөрт нухлагдан, боловсорч улс орны хэрэгт оролцох байтугай "хөмөрсөн тогоо"-

н дотроо өчүүхэн ч чөлөө завгүй байсныг дараах түүхэн баримт бичгүүдээс харж болох ажээ.

XX зууны эхэн үеийг хүртэл монгол эмэгтэйчүүд улс төр нийгэм, эдийн засгийн эрх мэдлийн хувьд хязгаарлагдмал байсан талаар XX зууны нам төрийн зүтгэлтэн Ю.Цэдэнбал "Ардын хувьсгал мандахаас өмнө Монголын эмэгтэйчүүд нь гэрийн боол, шивэгчний байдалтай хамгийн харанхуй бүдүүлэг, эрх мэдэлгүй, ад үзэгдсэн хэсэг нь байв" (Цэдэнбал 1961: 351) хэмээн дурьдсан байна. Гэвч хувьсгалын өмнө монголын эмэгтэйчүүд нийгмийн байдлаараа харилцан адилгүй байсан бөгөөд тухайн үеийн анги давхаргын аясаар ноёд баядын хатан охид, дунд ядуу, харц ард бүсгүйчүүд хэмээн давхраажиж харилцан адилгүй эрх мэдэлтэй байсан талаар түүхийн ном, зохиолуудад дурьдсан байна. Энэ үед эмэгтэйчүүдийн нийгмийн статус нь ураг төрлийн бүлгийн болон эр нөхрийн нийгэмд эзлэх байр сууриас голчлон шалтгаалдаг байсныг дараах жишээнээс харж болно. Монголын цагагчин гахай жилийн хувьсгал нь Ар, Өвөр Монголын шашны мяндагтнууд, төрийн түшээд, цэргийн жанжнуудыг нийгмийн давхраажлын оройд нь гаргасан билээ. Мөн тэдний их хатад тэдэнтэй эн зэрэгцэн байв. Ноён оргилд нь Монгол Улсын шашин төрийг хослон баригч хаан Богд Жибзундамба хутагт гарсан байна. Тэрбээр урьд нь зөвхөн шашны тэргүүн байсан бол одоо түүний гарт төрийн болон шашны бүх эрх мэдэл төвлөрөх болсон. Түүнийг дагалдан хатан Дондогдулам нь Улсын эх дагинаар өргөмжлөгдөн, ихэс дээдсийн зиндаанд дэвшсэн (Урангуа 2006: 204) байна.

1928 онд хэвлэгдсэн "МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд" хэмээх товхимолд "...Манай монголын түмэн эмэгтэйчүүдээс гэр малын хатуу ажлыг оролдсоор ирсний дотор зарим эмэгтэйчүүд жарган суух, зарим эмэгтэйчүүд ямар нэгэн аж үйлдвэрт дарагдсаар агсан хэдэн анги байдлыг ялгаварлан өгүүлбээс:

**Нэг:** Хаан, Ван, Гүн засаг ноёдын хатад авхай нар ба баялаг хөрөнгөтэй этгээдийн эмс охид

**Хоёр:** Дунд зэргийн амьдралтай малын ажилтай ардын эмэгтэйчүүд

**Гурав:** Амь ульжин тэжээх хөрөнгө өчүүхэн ч үгүй бөгөөд айлын ажил хийж амьдрах ядуу эмэгтэйчүүд байна хэмээн хуваагаад тэдгээрийн тус бүрийн байдлыг тодорхойлохдоо: "...Эдгээр гурван анги эмэгтэйчүүдийн аж амьдралын байдлыг харьцуулан үзвээс тэдний эрх мэдэл, зовлон жаргал, ашиг хорын явдал хоорондоо их л зөрүү ажгуу... Нэгдүгээр дэх хаад ноёдын хатан, авхай нар болбоос цаг ямагт өөрсдийн эр ба эцэг болох хаад ноёдын эрх сүрд, эрдэж зовлонт зүйлийг өчүүхэн ч үзэхгүй харин

## Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

ч ард олноос албадан гаргуулж авсан алт мөнгө, үнэт эрдэнэ, торгоор биеэ гоёмсоглон чимэглэж бусдад гоо сайхан үзэгдэхийг гол болгон, чухамхүү амтаныг ууж идэх зэргээр жаргал цэнгэлийг эдлэн түүнээс дагалт хиа нар буюу туслагч түшмэл, бичээч нар цаг бүр хатан авхай хэмээн сөгдөж, аливаа тушаасан захирсныг ёсоор дагаж гүйцэтгэнэ. Хэрэв тушаал зааврыг өчүүхэн төдий зөрчих буюу хайхрахгүй удаашруулахад хүргүүлбээс мөнхүү хэмжээгүй эрхтэй хаад ноёдоо ховлон хэлж, хутган үймүүлж хөөрхий тэд нарын мах ясанд хүргүүлэн жанчих, гүвших зэргийн аймшигт зовлонд учруулсаар байсан...”(Чимидцэрэн 1973: дам ишлэв). Гэвч эмэгтэйчүүдийн дийлэнх нь нийт ард түмний нэгэн адил олон төрлийн алба гувчуурт нэрвэгдэн үгүйрэл хоосролын туйлд хүртэл ядуурчээ. Ийнхүү хоосорч ядууран амь тэжээх хөрөнгө чинээгүй болсон өнчин ядуу эмэгтэйчүүд амь зуухын эрхээр үр хүүхдээ дагуулан, зарагдах айл, ширэх ул, элдэх арьс нэхий эрж, ноёд баядад үнэ хөлсгүй шахам зарагдаж байв. Энэ тухай дээрх баримтад дурдахдаа: “...огтхон ч амь тэжээх хөрөнгө чинээгүй айлын зарц буюу, өнчин бэлэвсэн эмэгтэйчүүд ...амь улжин тэжээхийн эрхээр биеэ нэгэн хөрөнгөлөг этгээдэд хүчин үнэлэгдэж тэдний бүхий л хатуу ажилд зүтгэмүй. Авах хөлс олз бага бөгөөд зөвхөн ганц биеийн идэх өмсөхийн зүйлд арай ядан хүрэлцэх буюу хүрэлцэхгүй ч буй... Ядуу хоосон буурай болсон өвчин эмгэгт баригдсан зарим эмэгтэйчүүд бусдын ажлыг хийж үл чадах тул цаг ямагт бусдаас идээ хоол гуйж амьдрах бүлгээ...” (Чимидцэрэн 1973: дам ишлэв) хэмээн өгүүлжээ.

Эмэгтэйчүүдийн гэр бүлд гүйцэтгэх үүрэг нь "... Хамгийн түрүүнд гэр хогшлыг хямгадмуй. Түүний дараагаар араг саврыг үүрэн хашлага тэргийг хөтлөн гадна одож аргал түлээ түүмуй, түүнийг гүйцэтгэж ирмэгц гэрийн доторх гал түлээ, тогоо шанага барих, хоол цай бэлтгэх, үнс хог гаргах, ширдэг дэвсгэр шүүрдэх, малын хэвтэр бууцыг малтах, мал бэлчээрлүүлэх, идээшлүүлэх зэргээр чөлөө завгүй сандран мэдрэн явмуй. Басхүү өглөө үдэш ба өдрийн үдэд үхэр, хонийг сааж идээ боловсруулмуй. Ялангуяа өвөл цагийн зуд гачигтай улиралд амин тэжээлийн малаа асран хамгаалж, ган зуд болоогүй өвс бэлчээр сайхан үед хэвтэр бууц тэгш нутгийг эрэн нүүж явдаг...” (Чимидцэрэн 1973: дам ишлэв) байжээ. Ийнхүү XX зууны эхэн үеийн монгол бүсгүйчүүдийн дийлэнх хэсэг нь тоононы голоос хойш алхах эрхгүй, нуруунаас араг салгаж, өндөгнөөс хуруувч сугалж, галын хайчнаас гар мултлах эрхгүй байсныг ардын дууны Сийлэн бөөр, Бүжмаа (Гандан уулын цэцэг хэмээх домогт дууны баатар), Шармаань (Тоорой баньд), Гүнжидмаа (Хулсан ташуур) зэрэг дүрүүд мөн тод илэрхийлж байна (Долгорсирэн 2006: 57).

Эрт дээр үеэс уламжилж ирсэн нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлд эмэгтэйчүүд, хүүхдийн оролцоо илүү байдаг болон эрэгтэйчүүдийн нэлээд хэсэг нь нийгмийн үйлдвэрлэлээс хол хөндий сүм, хийдэд шавилан сууж байсан нь дундаж болон дундажаас доогуур амьдралтай эмэгтэйчүүдийн нуруун дээр ийнхүү их ачааг үүрүүлжээ. “Монголд эмэгтэйчүүд, хүүхэд хоёр л ажилладаг бөгөөд аргал түүх, гал түлэх, хоол цай хийх, мал саах, дээл хувцас оёх шидэх энэ бүгд эмэгтэйчүүдийн нуруун дээр тохоостой байдаг. Хүүхдүүд (хөвгүүд, охид) хонь мал хариулна. Ийм учраас эмэгтэйчүүд, хүүхдүүд амин эрчим ихтэйгээрээ ялгарах бөгөөд зан төрхийн төрөлхийн назгай байдал тэдэнд багаар илэрдэг” (Майский 2001: 48) байв. Гэр орны ажлын голыг эмэгтэйчүүд нугалж байсан учраас өрх гэрийн дотоод асуудалд эмэгтэйчүүдийн нөлөө тодорхой хэмжээгээр байсныг үгүйсгэх аргагүй. Үнэхээр ч бүсгүй хүүхдийг эрд гаргах эсвэл хүүг гэрлүүлэх мэтийн асуудлыг эр нөхөр эхнэртэйгээ зөвлөлддөг нь ердийн хэрэг бөгөөд, түүний зөвшөөрөлгүйгээр нүүх суух ажил юм уу ямар нэг мал гадагш худалдах зэргийг эр нөхөр дангаар шийддэггүй (Майский 2001: 68) байжээ.

Эмэгтэйчүүдийн гэрлэлтийн дундаж нас 15-16 байсан бөгөөд ламд төөргөө үзүүлж эр эм бололцохыг албан ёсны гэр бүл гэх боловч амьдрал дээр зүгээр хамтран амьдрах явдал түгээмэл (Майский 2001: 339) байжээ. Хүүхэд төрүүлээгүй эхнэрийг дуртай цагтаа төрхөмд нь буцаах үзэгдэл нийтлэг байсан. Зарим нэг хошууны ноён голдуу анхны нь эхнэрээс нуган хөвгүүн төрөөгүй бол 2-3 эхнэр гэртээ байлгах нь ажиглагдана. Олон эхнэртэй тохиолдолд Их эхнэр (хатан) залуу эхнэрийг бодвол давамгай эрх эдэлдэг байжээ. Хүн амын бусад хэсэгт нь нэг эхнэр буюу нөхөртэй байх ёсыг ёсчлон баримталдаг хэмээн И. М. Майскийн өгүүлснээс харахад олон эхнэртэй байх явдал XX зууны эхэн үеийн монголын нийгэмд ховор тохиолдож байсан мэт.

Гэр бүл цуцлалтыг заримдаа ламаар адислуулдаг боловч зүгээр л хоёр тийшээ нүүх нь түгээмэл байжээ. Нөхөр нь эхнэрээ гурвантаа хөөж туусан байвал, эсвэл хөөгөөгүй байхад эхнэр нь гурван удаа эцэг эх дээрээ очсон л бол гэрлэлтээ цуцлуулах хангалттай үндэслэл болдог байжээ. Гэр бүл цуцлахад эхнэр хүн инжээ авах эрхтэй боловч нөхөртэйгээ хамт буй болгосон эд хөрөнгөөс хуваалцах эрх байдаггүй. Төвийн бүс нутагт хүүг нь эцэгт нь, охиныг нь эхэд нь үлдээдэг байсан бол Баруун монголд нөхрийн санаачлагаар салж байгаа бол эцэг нь охиноо авч эхнэр нь хөвгүүдээ авдаг, харин эхнэрийн санаачлагаар салж байгаа бол бүх хүүхдийг нь эцэгт нь үлдээх бөгөөд хожим тулах хүч болгон нэг хүүг эхэд нь үлдээдэг байжээ. Төвийн бүс нутагт эцэг хүн нас барвал хөрөнгийг гэр бүлийн гишүүд болох эх, хүүхдүүд тэнцүү хувааж авдаг,

харин хүүхэдгүй бол эхнэр зөвхөн инжээ авах эрхтэй байсан бол баруун бүс нутагт эцэг хүн нас барвал бэлэвсэн эхнэр 1/4-ийг, үлдсэнийг нь хүүхдүүдэд хуваахдаа хөвгүүдэд охидынхоос арай илүү хувь оноодог байжээ (Майский 2001: 339-340). Мөн хувь хөрөнгөө аваад айлд очсон охин нь төрсөн гэрээсээ дахин эд хөрөнгө авах учиргүй гэдэг (Бат-Ирээдүй, Арьяасүрэн 1999: 212). Энэ бүхнээс харахад гэрлэлт, гэр бүлийн эрх, өмч хөрөнгө, хүүхдийн талаар эдлэх эрхийн тухай хууль зүйн нарийн зохицуулалт байгаагүй ч эмэгтэйчүүдийн гэрлэлтээ цуцлуулах, өмч хөрөнгө өвлөх зэрэг эрх нь тодорхой нөхцөл байдалд уламжлалын хэлбэрээр зохицуулагдаж байжээ. Харин эхнэр нөхрийн эд хөрөнгөө тусдаа өмчлөхийг хязгаарлан эхнэрийн инжийг дундаа ашиглаж байснаас эмэгтэйчүүдийн захиран зарцуулах эрх мэдэл байгаагүй, эмэгтэйчүүдийг богтлох, насанд хүрээгүй охидтой гэрлэх, чөлөөтэй гэрлэх эрхгүй байсан зэрэг эмэгтэйчүүдийн эрх ихээхэн зөрчигдөж байсныг дурьдахгүй байхын аргагүй. Монголчуудын дунд эмэгтэйчүүдийг албадан гэрлүүлэх явдал нийтлэг байсан бөгөөд сүй бэлгийн заншилд өртөгдсөн бүсгүйчүүд "...Сүйдэж ганихарсан сэтгэлтэй..."(Ган төмөр) болж, зүс үзэж, үг солиогүй эр, тэр ч бүү хэл "...Хөгшин буурал баянтай" (Сэндэр охин), эсвэл хятадын мөнгө хүүлэгч худалдааны данжаадтай албан хүчээр дэр нийлүүлэх болдог хатуу хувь заяаг үйлийн үрийн номлол ёсоор үзэж ирсэн нь ардын дуунд:

“...Үйлийн лайтай төрснөөс хойш

Үглэж хэлээд яахав” (Жаалхан шарга хэмээх домогт дуу) гэх зэргээр туссан байна (Долгорсүрэн 2006: 57). Энэ үед охины сүй, инжинд өгөх хөрөнгө мөнгөний хэмжээг тогтоож бүр ёс болгон журамлаж байжээ. Жишээлбэл: Дунд зэргийн хөрөнгөтэй хүн охины сүйд хоёр морь, 30-40 лан мөнгө, өдий төдий хадаг бэлгийн зүйл өгдөг, инжинд нь 4-5 үнээ, мөн тооны гүү, 2-3 тэмээ, 30-40 хонь өгдөг ёстой байв. Баячууд бол сүйд хэдэн зуу, мянган лан мөнгө өгөх ба охины инжинд бас хэдэн арван бод, өдий төдий бог мал дагуулдаг байжээ. Харин ядуучууд 2-3 хонь, хэдэн ширхэг хадаг өгөхөөс хэтэрдэггүй байлаа (Майский 2001: 66).

Өгүүлэн буй үед монголын, ялангуяа дээд ангийханы дотор бэлгийн амьдрал их эрт эхэлдэг байв. Эмэгтэйчүүдийн дотор 14-15 насандаа ээж бологсод тааралдах бөгөөд бутач хүүхэдтэй байхыг шившиг гэж үздэггүй, хүүхэд эхийнхээ гэрт өсч хүмүүждэг болохоор энд охидууд баруун солгойгүй “нүгэл” үйлддэг (Майский 2001: 55-56) хэмээн монгол охидын хормой султайг И. М. Майский нэгэнтээ өгүүлжээ. Түүнчлэн буддын шашны нөлөөгөөр санваартан эрэгтэйчүүд гэр бүл болох нь хориотой байснаас

эмэгтэйчүүд "бутач" хүүхэд төрүүлэх явдал элбэг байсан (Урангуа 2006: 182) нь өрх толгойлсон ядуу эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байхад нөлөөлсөн.

1925 оны 10-р сарын 30-нд засгийн газраас тогтоол гаргаж эмэгтэйчүүдийг богтлох явдлыг албан ёсоор зогсоосон байна. Энэхүү тогтоолд “Эмс охидыг эрд богтлон өгөхдөө дур саналыг авах ч байтугай харин нууцаар түүний эцэг, эх буюу төрөл садны хүмүүс хуучин хууль дүрмийг баримтлан сүй богт гэж үнэ өртөг хэлэлцэн шууд албадан өгч ирсэн нь одоо харштай зүйл мөн тул тийнхүү хуучин бүдүүлэг хууль дүрэм зан суртлаар сүй богт гэж адгуус мал худалдах мэт дарлах явдлыг шууд зогсоож тус улсын хуулийг тодорхойлон тогтоохын наана аливаа эр, эм хүмүүс нийлж суух явдлыг хоёр этгээд завсраа санаа нэгдэж тохирон тогтоох бол тус улсын харьяат газар мэдүүлэн батлуулж дагаж явуулбал зохино...” (Чимидцэрэн 1973: дам ишлэв) гэж заажээ. Ийнхүү гэрлэлтийг хосуудын сайн дурын хэрэг болгосноор нийгмийн анхдагч нэгж болох гэр бүл дэх эмэгтэйчүүдийн эрхийг анх эрх зүйн хувьд баталгаажуулсан байна.

И.М.Майский "...Өргөөгийн бараг бүх эмэгтэйчүүд янхан болох хэрэгт хүчин зүтгэж байна. Хот, том хийд бүрийн захад ярайсан олон гэр байх бөгөөд тэнд янхан хүүхнүүд, бас зарим нь гэр орныхонтойгоо хамт суух нь цөөнгүй..." (Майский 2001: 56-57) хэмээн тэмдэглэн үлдээжээ. 1911 он хүртэл Манжийн засгийн газар монголд хятад эмэгтэйчүүдийг нэвтрүүлэхийг хориглож байсан учраас Өргөө, Улиастай, Ховдод арилжаа наймааны сонирхлоор ирсэн 15-50 насны мянга мянган (ойролцоогоор 100 000 орчим) хятад эрчүүд монгол хүүхнүүдийг хажуудаа байлгах “Зуурдын гэрлэлт” өргөн дэлгэрсэн нь анх монголд биеэ үнэлэгчид бий болоход голлох үүрэг гүйцэтгэжээ. Нөгөө талаар лам нар эмэгтэйчүүдтэй “хууль бусаар” түр энгэр зөрүүлэх буюу бүр хамтран урт хугацаанд батжилтай, бараг гэр бүл мэт байдаг зэрэг нь үндсэндээ янхан буй болохын шинж төрх (Майский 2001: 56-57) -ийг хөхүүлэн дэмжжээ. Ийнхүү "эмс, охид улс нийгмийн зохисгүй уур амьсгалын золиос" (Урангуа 2006: 201) болж байсан хэдий ч сахил хүртсэн лам нарт шашны дэг жаягийг дагаж мөрдүүлэх үүднээс эмэгтэйчүүдийг хууль цаазын зохицуулалтаас ангид байлгасангүй. Жишээ нь: 1913-1918 онуудад дагаж мөрдөж байсан "Аливаа лам нар Хороо харчуудын газраа хольцолдон муу самуун явахыг цагдан цээрлүүлэх учраа тогтоосон гучин хоёр зүйлийн дүрэм"-д хүрээний дотор эмэгтэйчүүд ямар үед хэрхэн орж болохыг хатуу тогтоон өгчээ. Түүнчлэн олноо өргөгдсөний 2-р он 12-р сарын шинийн дөрвөнд Шанзавын Яамнаас аймаг хошууд, их өртөө, говь хангай зүгийн сумын захирлуудад тушаан явуулсан нэгэн бичигт



## Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

«...Байцааваас урьд буулгасан зарлиг лүндэнгийн дотор эмс охид шар улбар, шар өнгийн хувцас хэрэглэж үл болох ба хүрээ эргэх замаас дотогш орж явах суухыг урьд удаа цаазлан тушаасан хэрэг нэн олон боловч ойрноос эмс охид хааяа шар өнгөт хувцас өмсөж явах нь буй ба басхүү хүрээ дотогш зоргоор орж суух ба явах мөн буй нь тогтоосон дүрэм заасан өдөр удаан хугацаагаар хоцроход хүрээд их л цалгардсан тул Шанзав Яамнаас дахин чангалан цаазалж, ухуулах бичиг дахин гаргаж, дөрвөн аймгийн дарга жанжин, нийслэл хүрээний дөрвөн аймгийн газрын жасаа... нарт тушаал хүргүүлсний учир... өөр өөрийн харьяат газарт нийтээр зарлан тушааж мөрдөн дагаж явуулахыг...мэдтүгэй...» гэсэн тушаалыг бүх аймаг хошуудад явуулжээ.

Сайн идэх, уух, торго дурдан хэрэглэх, үнэт эдлэл зүүх зэрэг амьдралд олдож болох бүх буяныг ашиглахын тулд янхан хүүхэн энэ мэргэжлийн ажлыг 14-15 настайгаасаа эхлэн хийдэг байжээ. Янхан хүүхнүүдийн өвөрмөц онцлог нь гангалах, хээнцэр чимэг зүүх их дуртай бөгөөд дэндүү үрэлгэн учир хамт амьдарч буй хүнээ хоосруулах нь цөөнгүй. Тэд 25 хүрээд л хөгширч эхэлдэг болохоор гэр бүл болох хуурамч ёслол хийдэг байсан. Нөхөрт гарсан эхнэр хүний үсний заслага, өмсгөлийг хөгширч байгаа янхан хүүхнүүд дууриах нь өөрийн нас намбанд илүү зохимжтой гэж үздэг байв. Гэвч тухайн үед гэрлэх албан ёслол хийгээгүй бол эхнэр хүний үсний заслага, өмсгөлийг хэрэглэж болохгүй байсан учраас янхан хүүхнүүд ламд очиж тусламж эрдэг, лам ч хүссэн ёсоор болзсон өдөр анд нөхөд, танил талынхныг нь байлцуулан жинхэнэ гэрлэх ёслолын үйлдлийг дууриалгаж хийлгэнэ. Энэхүү сувай гэрлэх ёслол үйлдсэний дараа жижиг найр хийсэн болоод "залуу" бүсгүй эр нөхөргүй хэр нь эхнэр хүний өмсгөл хэрэглэх маргашгүй бүрэн эрхийг олж авна. Эхнэр өмсгөлтэй хуучин янхан хүүхний энэхүү дүр зураг нь нас явж буйг илэрхийлэх, гэр бүлийн амьдралыг санагалзах гунигийг илэрхийлдэг ч байж болох юм. Түүнчлэн залуудаа янхан явсан эмэгтэй хөгшин болсон хойноо чавганц болж сахил санваар хүртэн залуу насныхаа нүглийг наманчилан суух явдал цөөнгүй тохиолддог байжээ.

Дөрвөдийн том ноёдын нэг Зоригт хан Ховдын нэг янхан хүүхэнтэй албан ёсоор гэрлэж байсан, Гадаад хэргийн сайдын алба хашиж байсан халхын том ноён Ачит Ван янхан хүүхнийг төрсөн дүүгээсээ салгаж ирээд сууж байсан (Майский 2001: 56) зэргээс харахад ноён хүн янхан хүүхэнтэй суухаас цээрлэхгүй байгаа нь янхан болох явдлыг төдийлөн буруушааж байгаагүйг илтгэх мэт. Олон лам нар сахил санваараа умартан албан бусаар эмэгтэйчүүдтэй хамтран амьдарч ирсэн нь монголчуудыг эмэгтэй хүний биеэ үнэлэх явдалд шашинтай холбогдуулж хүлцэнгүй хандахад хүргэсэн байж болох юм.

Хэдийгээр ухаалаг, гэрийн сайн боловсролтой эмэгтэйчүүд нийгмийн дээд давхраанд олон арваараа байсан ч "Эмэгтэй хүний үс нь урт, ухаан нь богино", "Янтгар хатан зарга шүүдэггүй" хэмээн үзэх хандлага монголчуудын дунд нийтлэг байснаас эмэгтэйчүүдийг төр улсын хэрэгт оролцох оролцоог төдийлөн дэмждэггүй байсан. Академич Ж.Болдбаатар "Монгол эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо: Уламжлал, шинэчлэл" Эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн "Монгол төрийн хатдыг шилж сонгож байсан түүхэн уламжлалын тухай асуудалд" сэдэвт илтгэлдээ "ХХ зуунд эмэгтэйчүүдийг үнэлэх хоёр чиглэл хандлага байна. Эхнийх нь 1921 оны хувьсгалын өмнө эмэгтэйчүүдийг "эрийн боол, гэрийн зарц" болгож байсан гэсэн хэт ангичирхсан чиглэл, хоёр дахь нь үүнээсээ үүдэн эмэгтэйчүүдийг нийгмийн дарлалаас чөлөөлөх, улс төрийн амьдралд идэвхтэй оролцуулах чиглэл барьж байв. Эхний чиглэлтэй холбоотойгоор "Эрийн эрдэмд жаргал, эмийн ухаанд лай", "Эр хүн гэрээс гарахлаар эр морины олзтой, эм хүн гэрээс гарахлаар эм ямааны гарзтай" гэх мэт эмэгтэйчүүдийг дорд үзсэн хандлага цухалзаж байсныг үгүйсгэх аргагүй юм. Гэхдээ дорно дахины бусад олон орны эмэгтэйчүүд шиг монгол бүсгүй "гэрийн боол" болж байгаагүй бөгөөд гэрийн доторх хэрэгт айлын эхнэр чухам л эзэн сууж, эр нөхрийнхөө бат бэх ар тал болж байсан билээ. Үүнээс үүдэн "Намар бугын амийг согоо авч явдаг" хэмээх онч мэргэн үг гарчээ. Ийм ч учраас монголчууд "Хөвгүүнийг ухаантай нь барилдуул, охиныг урагтай барилдуул" хэмээн үеийн үед сургаж иржээ" (Болдбаатар 2007: 27) хэмээн дурьдсан.

Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтөөр монгол эмэгтэйчүүдийн ухамсар сэргэж тэмцэлд оролцож байсан талаар академич Б.Ширэндэв "Монголын ардын хувьсгалын түүх" номдоо "Автономийн үеийн ардуудын хөдөлгөөний нэг онцлог нь эмэгтэй зарц Янжинхүү, Маамхүү нарын зэрэг эмэгтэйчүүд нийгмийн тайзан дээр гарч ирсэн явдал юм" (Ширэндэв 1969: 82) хэмээн өгүүлжээ. Хувьсгалын үйл хэрэгт С.Янжмаа, Дэмпин нарын эмэгтэйчүүд идэвхийлэн оролцож явсан талаар түүхийн ном зохиолуудад дурьдсан байдаг. Мөн тэмцэлд гар бие оролцоогүй ч журамт цэргийн хувцас оёх, цэрэгт хоол хүнс нийлүүлэх, мэдээ хүргэх зэргээр Г.Лувсан, Долгор, Цэрмаа, Тамба, Паш, Гарамцоо, Очирцоо, Дарь, Бүдцоо нарын эмэгтэйчүүд арын албанд зүтгэн хувьсгалын үйл хэрэгт хувь нэмэр оруулжээ.

1924 онд баталсан БНМАУ-ын анхдугаар үндсэн хуулиар эмэгтэйчүүдэд тэгш эрхийг анх олгосон бөгөөд тус хуулийн 3-р бүлгийн 11-р зүйлд "Тус улсын харъяат ард түмэн угсаа, шашин шүтлэг, эрэгтэй, эмэгтэй хэмээх ялгаварлалгүй нэгэн адил эрхийг

## Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

эдэлбэл зохино" (Чимидцэрэн 1973: дам ишлэв) хэмээн жендэрийн тэгш байдлыг анх хуульчилсан. Мөн 34-р зүйлд "18 насанд хүрсэн манай орны бүх иргэн нь эрэгтэй, эмэгтэй ялгаагүй улс төрийн бүхий л байгууллагад сонгох болон сонгогдох эрх эдэлнэ" хэмээн эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг хүлээн зөвшөөрч, эмэгтэйчүүдийг ялгаварлан үзэж байсан хуучин хууль, хязгаарлалтуудыг хүчингүй болгох, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг тунхагласан хууль дүрмүүдийг цаашид батлан гаргах болжээ.

МАХН-ын анхдугаар Их хурлаас баталсан "Эрмэлзэх 10 зүйл" буюу анхны программд "Манай ардын намд орж монголын үндэсний их үүрэгт зүтгэсүгэй хэмээсэн монгол үндэстний авгай нар, дээдэс доодос лам, хар, эрэгтэй, эмэгтэй хэн ч атугай буюу агаад ийнхүү үнэнч шударга явдалтан, манай намын суртлыг зөвшөөрөн хүлээж намын дүрмийг дагах нь болбоос бид нар намдаа багтаан авна" (Чимидцэрэн 1973: дам ишлэв) гэж заасан нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжсэн томоохон алхам байлаа. Мөн 1926 онд батлагдсан БНМАУ-ын Шүүх цаазны бичигт анх удаа эмэгтэйчүүдийн улс төр, хөдөлмөрийн болон хувийн эрх чөлөөг элдэв гэмт халдлагаас хамгаалах хэм хэмжээнүүдийг тогтоож өгсөн нь улс төр, нийгэм-эдийн засгийн үйл хэрэгт эмэгтэйчүүдийн оролцох оролцоог баталгаажуулан, дэмжсэн хэрэг болжээ. Эдгээр бодлого, шийдвэрийн үр дүнд 1923-1924 онд орон нутгийн засаг захиргааны ардчилсан сонгуульд эмэгтэйчүүд идэвхтэй оролцсон төдийгүй 1925 оноос төв орон нутгийн засаг төрийн байгууллага, ардын хурлуудад эмэгтэйчүүдийн төлөөлөгчид сонгогдох болсон байна.

1925 онд хуралдсан БНМАУ-ын II их хуралд анх эмэгтэй төлөөлөгчид сонгогдон оролцжээ. Тус хурлын 94 төлөөлөгчдийн 5 нь эмэгтэй төлөөлөгч байсан бөгөөд БНМАУ-ын II их хурлаас тус улсын төрийн дээд эрх барих Бага хурлын тэргүүлэгч 45 хүнийг сонгоход Богд хаан уулын аймгийн төлөөлөгч Хоролсүрэн, Хантайшир уулын аймгийн Сэцэн сартуул хошууны төлөөлөгч Намжилсүрэн, Цэцэрлэг мандлын аймгийн Баянзүрх уулын хошууны төлөөлөгч Лувсандулам нарын 3 эмэгтэй сонгогдсон (Чимидцэрэн 1973: дам ишлэв) нь шийдвэр гаргах төвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог баталгаажуулсан дээрх бодлогын тод илрэл болж энэ үеэс эхлэн монголын эмэгтэйчүүд төрийн болон олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болжээ.

1927 онд нам, эвлэлийн улсын их, бага хурал, орон нутгийн хурлуудад 200 гаруй эмэгтэй төлөөлөгч оролцож байв. 1924-1925 оны үеэс орон нутаг засаг захиргаа, төрийн яамд, үйлдвэр аж ахуйн газрууд, нам болон олон нийтийн байгууллагад алба хаадаг

эмэгтэйчүүдийн тоо олширсон. Тухайлбал: 1923 оны үед улсын байгууллагад зөвхөн 7 эмэгтэй ажиллаж байсан бол 1924 онд 38 болж өсчээ. Энэ тоо 1926 онд 60 гаруй болж өссөн төдийгүй 1928 онд 70 гаруй эмэгтэй засаг захиргааны албанд, 160 гаруй эмэгтэй нам ба эвлэлийн байгууллагуудад ажиллах болжээ (Чимидцэрэн 1973: дам ишлэв). Зарим баримтаас үзэхэд 1928 он гэхэд алба хааж буй эмэгтэйчүүд 200-300 шахам байжээ.


1930 оны Намын төв хорооны Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрт: “Сумдын доторх аль бололцох газарт эмэгтэйчүүдийн хурлыг дахин дахин чанартай хуралдуулахаас гадна хот, суурин газрууд, мөн зарим нэгэн хошуудад дөхөмтэй бол төлөөлөгчдийн хурлыг хуралдуулж болох” тухай заажээ. Энэ нь төр, засгаас гаргасан эмэгтэйчүүдийн хурлыг зохион байгуулах замаар эмэгтэйчүүдийг төрийн хэрэгт оролцуулах, тэдний улс төрийн идэвхийг дээшлүүлэхэд чиглэгдсэн бодлого байлаа. Тухайн үед эмэгтэйчүүд гэрээсээ гарч хуралд сууна гэдэг нь эрэгтэйчүүдийн хувьд эвлэршгүй, харин шашны хурлаас өөр хурал цуглаанд сууж үзээгүй эмэгтэйчүүдийн хувьд улс төрийн эрхээ эдлэх чухал үйл явдал байлаа. Ноён уулын хошуунд эмэгтэйчүүдийн хурал дээр хэсэг эрчүүд орж, “эмэгтэйчүүд төрийн хэрэгт оролцоно гэдэг буруу. Хүүхэн хүн төрийн хэрэгт орох, наадамд гүү уралдах хоёр адил” гэсэн нь түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

1931 онд явагдсан сонгуулиар орон нутгийн засаг захиргаанд 600 шахам эмэгтэйчүүд сонгогдсон нь бүх сонгогдогсдын 30%-ийг эзэлж байв. Эдгээр сонгуульд ажилтай 600-гаад эмэгтэйчүүдийн 2 нь аймгийн захиргааны дарга, 6 нь аймгийн хэлтсийн эрхлэгч, 30 нь сум, хорины дарга байжээ. Энэ үед төрийн сайд, орлогч сайд, яамд ба тусгай газрын дарга эрхлэгчид 16 хүн ажиллаж байсан (Чимидцэрэн 1973: дам ишлэв) байна. 1940 онд явагдсан засаг захиргааны сонгуулиар 4000 эмэгтэй, төрийн дээд эрхийг барих БНМАУ-ын бага хурлын гишүүнд 14 эмэгтэй сонгогдон ажиллаж байснаас харахад монгол улс XX эхэн үе гэхэд шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг 30 хувьд хүргэж жендэрийн тэгш байдлыг хангахад ихээхэн амжилт олж байжээ.

1929 оноос эхлэн олон эмэгтэйчүүд ардын шүүхийн байгууллагад сонгогдох болж ардын төлөөлөгчдийн бараг 50%, аймаг хотын ба аймгийн шүүн таслах газруудын гишүүдийн 35%, бүх шүүгчдийн 30% -ийг эмэгтэйчүүд эзэлсэн. Түүнчлэн хоршооны удирдах ажилд 40 шахам эмэгтэйчүүд ажиллаж байсан ба олон эмэгтэйчүүд үйлдвэрийн газруудад тасгийн эрхлэгч, сангийн аж ахуйн эрхлэгчийн ажлыг гүйцэтгэж байв.

## Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

1924 оны 3 сарын 19-нд монголын эмэгтэйчүүдийн байгууллагын анхны шавыг бага сургуулийн багш Хаснавч, Бадамренчин, Пагмадулам нарын эмэгтэйчүүд тавилцаж МАХН-ын Төв хорооны дэргэд эмэгтэйчүүдийн тасаг байгуулан түүнийгээ Ардын намын Төв хорооны суртлын хэлтсийн дэргэдэх “Бүсгүйчүүдийг боловсруулах тасаг” (Чимэдцэрэн 1973: 224) хэмээн нэрлэжээ. Энэхүү “Монголын эмэгтэйчүүдийн тасаг” нь эдүгээ хүртэл үйл ажиллагаа явуулж буй Монголын эмэгтэйчүүдийн холбоо болон өргөжиж олон эмэгтэйчүүдийн ТББ-ын үндэс суурь болсон билээ. Монголын эмэгтэйчүүдийг гэгээрүүлж боловсруулах, тэднийг улс төр, нийгмийн үйл хэрэгт зохион байгуулж оролцуулахад эмэгтэйчүүдийн олон нийтийн байгууллага ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.



**Зураг 2.** МХЗЭ-ийн гишүүн эмэгтэйчүүдийн тоо (1930)  
(Эмэгтэйчүүдийн санал 1928: 36)

1930 оны байдлаар МАХН-ын гишүүдийн 20%, МХЗЭ-ийн гишүүдийн 32% нь эмэгтэйчүүд (Чимидцэрэн 1973: дам ишлэв) болсноос харахад эмэгтэйчүүдийн нийгмийн амьдралд оролцох идэвх сэргэснийг харуулж байна.

Гэрээр бичиг үсэг заалгаж, унших бичих төдий болсон зарим нэг эмэгтэйчүүдийг эс тооцвол бараг эрдэм номын тухай төсөөлөлгүй байсан эмэгтэйчүүдийн боловсролыг дээшлүүлэх, мэргэжил олгох, нийгэм, улс төрийн амьдралд татан оролцуулах талаар тухайн үед засгийн эрхийг дангаар барьж байсан МАХН анхаарал тавьж иржээ. 1925 онд батлагдсан МАХН-ын II программын эмэгтэйчүүдийг гэгээрүүлэх талаар тавих намын зорилгод "... Монголын жинхэнэ ард эмэгтэйчүүдийг сурган гэгээрүүлж, улс төрийн хэрэгт нэгэн адил гэгээрүүлэхийг хичээнэ" (Чимидцэрэн 1973: дам ишлэв) хэмээн тусгасан байна. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд олон нийтэд эмэгтэйчүүдийг үндэсний бичиг үсэгт сургах намын бодлого зорилгыг ойлгуулах, төрөл бүрийн мэргэжлийн сэхээтэн эмэгтэйчүүдийг бэлтгэхэд гол анхаарлаа хандуулж Монголын эмэгтэйчүүдийн байгууллага, МХЗЭ-ийн байгууллагыг энэхүү үйл хэрэгт татан оролцуулсан байна. МАХН-ын Төв Хорооны

дэргэдэх эмэгтэйчүүдийн тасгаас эрхлэн 1925 онд өөрийн тогтмол хэвлэл “Бүсгүйчүүдийн санал” сэтгүүлийг хэвлүүлэн гаргасан нь эмэгтэйчүүдийг сурах боловсроход уриалан дуудаж сургалт суртачилгааны томоохон үүрэг гүйцэтгэжээ.

1925 оны IX сард хуралдсан МАХН-ын IV их хурал эмэгтэйчүүдийг намд олноор элсүүлэх, эмэгтэйчүүдийн байгууллагыг чадварлаг боловсон хүчнээр хангах зорилгоор МАХН-ын ТХ-ны дэргэд түр цагийн сургууль нээхийг заагаад эмэгтэйчүүдийн дунд зохиох ажилд намын бүх гишүүд идэвхтэй оролцохыг уриалсан байдаг. Дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор эмэгтэйчүүдийн тасгаас эрхлэн 1925 онд нийслэлийн нам, эвлэлийн бүх эмэгтэй гишүүн 72 хүнийг намын түр сургуульд суралцуулж тэдэнд үндэсний бичиг, тоо, сурган хүмүүжүүлэх ухааны анхны мэдэгдэхүүнийг заах болсноор 1931 он гэхэд 2000 шахам эмэгтэйчүүд бичиг үсэгт тайлагджээ. Мөн эмэгтэй боловсон хүчнийг бэлтгэх түр курсуудыг байгуулж эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгчид, аймгийн намын хорооны зааварлагч нарыг сурган хөдөө орон нутгуудад явуулж эмэгтэйчүүдийг соёлжуулах клуб, улаан булангуудыг олноор байгуулсан нь дээрх зорилтын хэрэгжилтэнд томоохон хувь нэмэр оруулсан байна.

Бага насны охидыг ардын сургуулиудаар сургах ажлыг 20-иод оноос эхлүүлсэн тухай Ө.Чимэд “Анхны бага сургуулиудын түүхээс” номондоо "1921 оны 11 сарын 2-нд Улаанбаатар хотын бага сургуулийг 100 орчим хүүхэдтэй нээсний дотор эмэгтэй сурагчид 40 байв" хэмээн дурьдсан байдаг. Түүнчлэн хуучин бичиг мэддэг буюу төсөөлдөг эмэгтэйчүүдийг оюутны сургуульд сургаж ардын багш нарыг бэлтгэж эхэлсэн. “Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүлийн 1928 оны нэгэн дугаарт “...бага сургуулийн 2915 сурагчийн 551, гадаадад сурах 160 сурагчийн 22, дунд сургуулийн 109 сурагчдын 30, оюутны сургуулийн 40 оюутны 5 нь эмэгтэй байна” гэснээс харахад бага, дунд тусгай мэргэжлийн сургуулийн эмэгтэй сурагчдын тоо эрс нэмэгдэж эмэгтэйчүүдийн боловсролын түвшинд эрс өөрчлөлтүүд гарч эхэлжээ. 1931 он болоход бүх бага сургуулийн сурагчдын 38% охид болсон бөгөөд жагсаалын сургуулийн сурагчдын 62.5%, төв кооперативный нягтлан бодохын сургуулийн сурагчдын 32%, сангийн яамны няглах бодохын сургуулийн сурагчдын 18.4%, жолоочийн сургуулийн сонсогчдын 10%, латин үсгийн багш нарыг бэлтгэх сургуулийн сурагчдын 44%, багш нарыг бэлтгэх техникумын оюутнуудын 25.6%, соёлын довтолгооны сургуулийн сурагчдын 13.5%-ийг эмэгтэй суралцагчид эзэлж байсан бөгөөд сестрагийн сургуульд 100, эмэгтэйчүүдийг дэвшүүлэх сургуульд 30, 6 сарын хугацааны эмэгтэй ажилчдын

## Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

түр сургуульд 44 охид суралцаж байжээ. Мөн гадаадад мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодлогын дүнд С.Янжмаа, Д.Батсүх, М.Дулмаа, Ц.Занаа, Д.Пагмадулам, Сурмаажав, Г.Батсүх нарын олон арван эмэгтэйчүүд 1920-иод оны дунд үеээс ЗХУ, Герман, Франц зэрэг орнуудад суралцсан.

Ийнхүү 1930-аад оны эцэс болоход эмэгтэйчүүдийн боловсролд асар их өөрчлөлт гарч шинээр төрөн гарсан мэргэжлийн сэхээтнүүдийн тодорхой хувийг эмэгтэйчүүд эзлэх болсон төдийгүй холбоо харилцаа, худалдаа санхүү, эмнэлгийн дунд мэргэжилтнүүдийн дунд зохих байр сууриа эзэлсэн байна.

1925-1926 онд Хүрээнд байсан Австрийн жүжигчин Страссер тэмдэглэхдээ: “...Нэлээд эмэгтэйчүүд өөрсдийнхөө оюуны хэр хэмжээг даан ч сайхан илэрхийлсэн гоё дээл өмсч байна. Бас шашны зааснаар толгойдоо том эвэр зүүж явдаг, шавар туучсан ээтэн хоншоортой, эрээн угалзтай гутал чирсэн, морины туурайг дуурайлган хийсэн нударга бүхий урт яндан маягийн ханцуйтай, адууны дэл шиг ширүүн үсээ хоёр эвэр болгон янзалсан өндөр жийргэвч бүхий мөртэй...байлаа. Монгол эмэгтэйчүүдийн зарим нь өдгөө Зөвлөлтийн үзэл санааг уухайн тас сайшаан авч, амьдралд эзлэх өөрийн байр сууриа, үндэснийхээ хувцасыг орхих хандлагатай болж байна. Тэд ерөнхийдөө шинэ чиглэлийг дагагчдын эхнэрүүд юм...Шинэ Монгол хуучныхаа хувцасыг үзэн ядаж, өөрсдийнхөө онцгой хөрөнгө болох гэрийг Оросын бараа, үзэл санааны хувьд санал болгож байгаа ойлгомжгүй шинэ зүйлийн дэргэд хэрэггүй гэж үзэж байлаа...” (Рупен 2006: 242) хэмээн монголын эмэгтэйчүүдийн оюун санаа, ялангуяа тэдний хувцаслалтанд хандах хандлагад гарч байгаа өөрчлөлтийн талаар дурьджээ.

Эмэгтэйчүүдийн тасгаас эрхлэн урлагийн авьяастай зарим эмэгтэйчүүдийг тухайн үеийн соёл хүмүүжлийн төв болж байсан Сүхбаатарын клубын хөгжим жүжгийн болон бусад мэргэжлийн бүлгэмүүдэд элсүүлэн сургах болсноор Дашдэлэг, Ичинхорлоо нарын алдартанууд төрөн гарсан юм.

1920-иод оны сүүлчээс эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд ахиц гарч эх нялхасын зөвлөл, мөн өнчин ядуу хүүхдийг асрах газар, хүүхдийн сүүний газрууд бий болж эхэлсэн. Үүний зэрэгцээ эмэгтэйчүүдэд чиглэсэн төрийн халамжийн бодлого хэрэгжин 1928 оноос эхлэн жирэмсэн эмэгтэйчүүдэд 3 сарын цалинтай чөлөөг олгох болжээ. 1929 онд Ардын гэгээрлийн яамнаас хүүхдийн цэцэрлэг, улаан гэрүүдийг орон нутагт гаргасан тухай Монголын эмэгтэйчүүдийн IV их хурлын илтгэлд дурьдсан байна. Үүнээс үзэхэд 1930-аад оноос эхлэн хүүхдийн цэцэрлэг, хүүхэд саатуулах газрыг улсын хөрөнгөөр байгуулан эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх явдлыг хүүхдийн ясли, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх замаар

онцгойлон дэмжиж эхэлжээ. Энэ тухай "Ажилчин эмэгтэй" сэтгүүлийн 1932 оны 6 сарын дугаарт "...1931 онд хөдөө газар ясли хэмээх газрыг байгуулсан амуй. 1932 онд эх ба нялхасыг хамгаалах ажилд төсөвлөлт 50000 төгрөг зарцуулахаар зориулжээ" хэмээн бичсэн байна.

1920-иод оны үеэс эхлэн эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг тунхаглаж хууль, эрх зүйн хувьд:

а) Эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэж байгаа ажил хөдөлмөрийг адил тэгш үнэлэх, мөн ижил хөлс олгох.

б) Эмэгтэйчүүдийн хөдөлмөр хамгааллын арга хэмжээг авах


в) Жирэмсэн эмэгтэйчүүдэд төрөхийн өмнө, хойно цалинтай чөлөө олгох зэргээр баталгаажуулж иржээ. Түүнчлэн харилцан туслалцах хоршоо болон жижиг үйлдвэрийн газрууд, тэр дундаа оёдлын газруудыг олноор байгуулж ядуу эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах үйл ажиллагаа явуулж ирсэн нь амжилттай хэрэгжсэн. "Гар үйлдвэрлэл болбоос өөрийн ажилд бүх ардыг оролцуулахыг гол зорилго болгохын хамт ялангуяа урлах, эсгэх нарийн оёдлын зэрэг элдэв ажилд эмэгтэйчүүдийг авч түүний аж амьдралыг дээшлүүлэх ба ажилд сургаж, үндсэн ажилчин болгох хийгээд сурган хүмүүжүүлж ирсэн. Хийгээд...гар үйлдвэрт ажиллаж буй монгол ажилчин 290 болохоос эмэгтэйчүүд 232 болно. Түүнчлэн урлан гаргах зүйлийн ихэнх хувийг эмэгтэйчүүд урласан нь илэрхий болох ба түүнчлэн удаан жил ажиллаж мэргэжил дадлагыг олгоно" (Чимидцэрэн 1973: дам ишлэв) хэмээн эмэгтэйчүүдийн сэтгүүлийн нэгэн дугаарт дурьдсанаас үзэхэд эмэгтэйчүүдийг гар үйлдвэрийн ажилд оролцуулахыг чухалчилж байжээ. Эмэгтэйчүүдийн байгууллагын анхны зүтгэлтэн Б.Хаснавч дурдатгалдаа "ажилгүй ядуу эмэгтэйчүүдийг ажиллуулах зорилгоор цэргийн гар үйлдвэрийг анх 1924-1925 онд байгуулж даргаар нь харцага Чин Вангийн авгай Эрдэнэчимэгийг ажиллуулж байсан юм" (Чимидцэрэн 1973: 52-53) гэжээ. Эмэгтэйчүүдийг юуны өмнө гар үйлдвэр, оёдол, нэхмэлийн газруудад олноор ажиллахыг төрөөс дэмжиж байсан нь тэднийг хөдөлмөр эрхлэлтэд татан оролцуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд мэргэжилтэй ажилчид дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өсөхөд нөлөөлжээ.

1930-аад оноос манай оронд аж үйлдвэр хөгжсөнтэй холбогдуулан, эмэгтэйчүүдийг шинээр байгуулагдсан үйлдвэрийн газрууд ялангуяа архи, арьс шир, туйпуу, төмрийн завод, оёдол, гутал, савхины үйлдвэрт ажиллуулах арга хэмжээнүүдийг авч тэдгээрт ажилчин элсүүлэхэд их анхаарч байв. Мөн гэгээрлийн яамны хэвлэлийн хороо, гар үйлдвэрийн эвлэл, оёдол, гутал савхины үйлдвэрийн 700



## Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ

ажилчдын 361 нь эмэгтэйчүүд байв (Чимидцэрэн 1973: дам ишлэв). Ийнхүү монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн эхлэл суурь тавигдсан бөгөөд эдүгээ нийт ажиллагсдын 46.3 хувийг (NSO 2002:65) эмэгтэйчүүд эзлэх болжээ.



**Зураг 3.** Үйлдвэрийн газрын ажиллагсад дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (1931он)  
(БНМАУ-ын ажилчин эмэгтэйчүүдийн анхдугаар их хурлын материал 1931: 24)

Хот суурин газрын эмэгтэйчүүдэд хандсан арга хэмжээнүүдийг авахын зэрэгцээ эмэгтэйчүүдийн олонхийг эзлэх хөдөөний бүсгүйчүүдийн дунд тэдний аж амьдралыг дээшлүүлэх, эдийн засгийн гол үндэс болж байсан МАА-г хөгжүүлэхэд тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, МАА-н таваарлаг чанарыг дээшлүүлэхэд эмэгтэйчүүдийн үүргийг дээшлүүлэх замаар малчин ардын гэр бүлийн амьжиргаанд оруулах эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон талт арга хэмжээ авч байв. Тухайлбал: МАХН-ын Ү их хурал эмэгтэйчүүдийн байгууллагын ажлыг авч хэлэлцээд хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд зохиох ажил хангалтгүй байгааг тэмдэглээд аймгуудын эмэгтэйчүүдийн салбаруудын ажилд хөдөөгийн эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулахыг заасан байдаг. 1927 оноос энгийн эмэгтэйчүүдийн хурлыг бүр хошуу сумдаар нь хуралдуулах болсноор хөдөөгийн эмэгтэйчүүдийн идэвх дээшилсэн. Мөн эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэхийн тулд эмэгтэйчүүдийн ядуу хэсэгт мал хөрөнгө хувь болгож өгөх, эмэгтэйчүүдийг анх үүсэж байсан ХАА-н нөхөрлөлд оруулах зэрэг арга хэмжээнүүдийг 1929-30 онуудад хэрэгжүүлжээ.

## ДҮГНЭЛТ

Энэ бүхнээс дүгнэн үзвэл ХХ зууны эхэн үед монгол эмэгтэйчүүд феодалын тогтолцоог халах, хувьсгалын ялалтыг бэхжүүлэхэд тэргүүн эгнээнд манлайлан оролцоогүй ч хоол хүнс, хувцас хунараар хангах, мэдээлэл хүргэх зэрэг ар талын албанд хүчин зүтгэж байжээ. Ийнхүү монголын ард түмний тэмцэн олсон хувьсгалын

үрээр эмэгтэйчүүд улс төр, нийгэм эдийн засгийн хувьд эрх чөлөөтэй болсон төдийгүй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг Монгол улс үндсэн хуулиндаа хуульчилж, эмэгтэйчүүдийн улс төр, хөдөлмөрийн болон хувийн эрх чөлөөг элдэв гэмт халдлагаас хамгаалах хэм хэмжээнүүдийг тогтоож өгсөн нь жендэрийн тэгш эрхийг хангахад чиглэгдсэн анхны томоохон алхам болжээ.

Хувьсгалын эхний жилүүдэд эмэгтэйчүүдийн талаар төр, засгаас явуулсан бодлого нь эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй нэгэн адил эрх, эрх чөлөөг эдлүүлэн нийгмийн хөгжил, дэвшилд мөр зэрэгцэн алхуулахад чиглэгдэж байв. Ялангуяа эмэгтэйчүүдийг гэгээрүүлэх, төрийг удирдах үйл хэрэгт оролцуулах, улс төр, иргэний эрхээр хангахад онцгой анхаарч байжээ.

Өгүүлэн буй үед эмэгтэйчүүд намын гишүүнээр элсэх, төрийн дээд байгууллагууд, улс төрийн албан тушаалд сонгогдон ажиллах болсон нь “янтгар хатан зарга шүүдэггүй” гэсэн уламжлалт ойлголтыг шийдвэр гаргагчдын дунд төдийгүй олон нийтийн дунд эвдсэн томоохон өөрчлөлт байлаа. Түүнчлэн эмэгтэйчүүдийн байгууллагаар дамжуулан тэдний идэвхийг өрнүүлсэн нь монголын эмэгтэйчүүдийг боловсрол, хөдөлмөр эрхлэлтэнд зохих байр сууриа эзлэхэд томоохон үүрэг гүйцэтгэсэн байна

Төрийн ивээл дор олон арван сургууль байгуулж өвсөр үеийнхнийг үнэ төлбөргүй сургах, гадаадад сурагчдыг илгээх болсон нь нийгмийн оюун санааны амьдралд томоохон өөрчлөлтийг авчирч эмэгтэйчүүдийн боловсролын түвшинг дээшлүүлээд зогсохгүй тэднийг гар урлалын болон хоршооллын үйл ажиллагаанд оролцуулах замаар хөдөлмөр эрхлэлтэнд татан оролцуулсан нь нүүдлийн мал аж ахуйн хүнд хөдөлмөрт хөлсгүй нухалагдаж ирсэн монголын дийлэнх эмэгтэйчүүд, тухайн үеийн нийгмийн зохисгүй уур амьсгалын золиос болж байсан олон арван биеэ үнэлэгчдэд хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх боломж олгож, цаашлаад мэргэжилтэй боловсон хүчин, хөдөлмөрийн сэхээтнүүдийн дунд зохих байр сууриа эзлэх боломжийг олгосон. Ийнхүү эмэгтэйчүүдийн эрхийг хэрэгжүүлэхэд их анхаарсан нь шинээр бүрэлдэн бий болж асан нийгмийн үзэл санаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлын талаарх ойлголтыг гүн бат суулгасан байна.

Монголын төрөөс авч хэрэгжүүлсэн эдгээр олон зорилт, хөтөлбөрүүдийг олон нийтэд ойлгуулах, эмэгтэйчүүдийн идэвхийг өрнүүлэхэд чиглэсэн бодлогын чанартай арга хэмжээг шат дараалсан байдалтай авч хэрэгжүүлсэнээр монгол эмэгтэйчүүд асар

богино хугацаанд сурч боловсрон улс төр, нийгэм-эдийн засаг, соёлын амьдралд эрчүүдийн адил идэвхтэй оролцох болжээ.

### НОМ ЗҮЙ

- Бат-Ирээдүй Ж, Арьяасүрэн Ч.*, 1999. “Монгол ёс заншлын их тайлбар толь”. МУИС-ийн Хэвлэл, УБ
- БНМАУ-ын Үндсэн хууль*. 1924 он
- Болдбаатар Ж.*, 2007. Монгол төрийн хатдыг шилж сонгож байсан түүхэн уламжлалын тухай асуудалд. Жендэр судлал, № 2. УБ (хэвлэлтэнд)
- Долгорсүрэн Ж.*, 2006. Монгол ардын дуу ба жендэр. Жендэр судлал. № 1. УБ
- Майский И.М.*, 2001. Орчин үеийн Монгол (Автомомит Монгол ХХ зууны гараан дээр). “Согоо нуур”, УБ
- МУИА*. А-3, Д-1, хн-97 42 дугаар бичиг. х .146-148
- МУУА*. 33.ф. А-3, д.1, хн 231. х.54
- Роберт А.Рупен.*, 2006. Хорьдугаар зууны монголчууд. Монсудар, УБ
- Урангуа Ж.*, 2006. ХХ зууны эхэн үеийн Монгол улс. “Соёмбо”, УБ
- Цэдэнбал Ю.* 1961-1966. Илтгэл өгүүлэл, хэлсэн үг. III боть. УХГ, УБ
- Чимид Ө.*, 1961. Анхны бага сургуулийн түүхээс. УХГ, УБ
- Чимидцэрэн Э.*, 1969. Монголын эмэгтэйчүүд шинэ амьдралын замд (1921-1931). УХГ, УБ
- Чимидцэрэн Э.*, 1973. БНМАУ-д эмэгтэйчүүдийг нийгмийн дарлалаас чөлөөлсөн түүхэн туршлага. УХГ, УБ
- Ширэндэв Б.*, 1969. Монгол ардын хувьсгалын түүх. УХГ, УБ
- NSO*, 2002. Gender in Mongolia: Analyses based on the 2000 census. Ulaanbaatar

### SUMMARY

Ts.Tsestegjargal

## ENGAGING THE MONGOLIAN WOMEN AT THE ONSET OF THE 20<sup>TH</sup> CENTURY INTO POLITICAL, ECONOMIC AND CULTURAL LIFE

*At the onset of the 20<sup>th</sup> century Mongolian women, as any member of the society, were diversified into differing strata according to their possession, social status of their spouses and kinship. Despite somewhat visible participation of women and children in traditional economic activities, and thus, more active role within the household, their socio-political status remained under heavy restraint. This was especially true for women of lower classes, who carried the main burden of daily economic life due to large number of men taken the vow of monastic life. Undeniably the women suffered from serious accounts of violation of their rights, such as the right to choose a spouse, to own property etc.*

*Another disadvantage women faced in the given period is their sexual subordination, coupled with easy-to-go attitude with which many in Mongolian society looked upon premarital and extramarital relationships, early childbirth and even prostitution, ultimately leading to virtual enslavement of many Mongolian women.*

*The victory of the 1921 national revolution brought about the emancipation of women, with universal suffrage granted by the 1924 Constitution and 1926 legal act providing for the protection of women's social, political and economic rights. As a result, over 600 women were elected to local assemblies, making the ratio of female representatives 30 percent of total – and by 1940, 14 women were elected members of the standing legislature of Mongolia. Thus, the first half of the 20<sup>th</sup> century was marked by all-round emancipation of Mongolian women, elevation of their educational and professional status and their ultimate inclusion into the social, political, cultural and economic life of the nation.*